

**ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ЖИЛИЙН
6-Р СУРГУУЛИЙН 2016-2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын баталсан 35/01/04 тоот удирдамжийн дагуу Жаргалант сумын 6-р сургуулийн 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Ховд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Г.Өөдэй санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Д.Болормаа, П.Мягмартүвшин нар 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс ажлын 10 өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Шалгалтыг Боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон салбарын онцлог үйлэжиллагаатай холбогдон гарсан яам тусгай газрын заавар журам, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилтийг тус байгууллагын харилцах, бараа материалын тооцоо, хөрөнгө оруулалт, цалингийн шатлал, бусад нэмэгдлүүд болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан шалгалаа.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Шалгагдах хугацааны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг 2016-2017 Л.Цэнд-Аюуш, Х.Гантөмөр 2018 оноос захирал Б.Барсболд хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Цэвэлмаа нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Тус сургууль нь Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Боловсролын тухай, Шилэн дансны тухай, Монгол улсын бусад хууль эрхзүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

2016-2017 онд 94 багш ажилчидтай, 2018-2019 онуудад 97 орон тооны багш ажилчидтай ажиллахаар төлөвлөснөөс удирдах 1, гүйцэтгэх ажилтан 76, үйлчилгээний 20 нийт 97 орон тоотой тус онд үйл ажиллагаа явуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС дагуу аккурель сууриар хөтлөж “СТS” бүртгэлийн программаар НББ –г хөтлөн явуулжээ.

Тав.Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар

2016 онд төсвөөс авах татаас санхүүжилтийн орлогоор 1296642.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 679.2 мянган төгрөг, нийт 1297321.8 мянган төгрөг татан төлөвлөрүүлж төсвийг захиран зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн хөрөнгийг зардлын зүйл ангилалаар авч үзвэл /мянган төгрөг/

ДД	Үзүүлэлт	2016 он		Хэмнэлт	Хэтрэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин	820923.8	835751.5		-14827.7
2	НДШ	90606.6	85193.7	5412.9	
3	Гэрэл цахилгаан	7333.7	5222.5	2111.2	
4	Түлшхалаалт	173539.4	191451.9		-17912.5
5	Цэвэр бохир ус	26363.0	27858.2		-1495.2
6	Үдийн цай	51147.0	51147.0	0	
7	Эм	512.5	551.0		-38.5
8	Бичиг хэрэг	854.2	4463.0		-3608.8
9	Тээвэр шатахуун	188.7	843.0		-654.3
10	Шуудан холбоо	1355.1	5501.5		-4146.4
11	Албан томилолт	341.7	812.0		-470.3
12	Төлбөрхураамж			0	
13	Ном хэвлэл	1025.1	409.0	616.1	
14	Хог хаягдал	512.5	509.4	3.1	
15	Зөөлөнэдлэл	2221.0	2238.5		-17.5
16	БҮТЭЗ	1366.8	2622.3		-1255.5
17	Хичээл сургалт	10018.4	5816.5	4201.9	
18	Урсгал засвар	2061.8	7919.2		-5857.4

19	Биеийн тамир, тэмцээн			0	
20	Аудит баталгаажуулалт	576.0	576.0	0	
21	ХОНТСА	63887.4	54899.7	8987.7	
22	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж	10344.5	13386.7		-3042.2
23	Бусад зардал	24492.0	149.2		
24	Төсвийн санхүүжилтээс	1289671.2	1296642.6		
25	НДСангаас				
26	Түрээсийн орлого		679.2		
27	Нийт зардал	1289671.2	1297321.8		
	Нэмэлт санхүүжилт				

2017 онд төсвөөс авах татаас санхүүжилтийн орлогоор 1363576.3 мянган төгрөг, өөрийн орлогоос 1405.4 мянган төгрөг, нийт 1364981.7 мянган төгрөг татан төлөвлөрүүлж төсвийг захиран зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн хөрөнгийг зардлын зүйл ангилалаар авч үзвэл /мянган төгрөг/

ДД	Үзүүлэлт	2017 он		Хэмнэлт	Хэтрэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин	829125.2	823522.2	5603.0	
2	НДШ	91203.7	98151.8		-6948.1
3	Гэрэл цахилгаан	6032.0	4102.7	1929.3	
4	Түлш халаалт	186888.6	187112.1		-223.5
5	Цэвэр бохир ус	26935.8	26518.2	417.6	
6	Үдийн цай	50983.9	50983.8	0.1	
7	Эм	796.0	884.6		-88.6
8	Бичиг хэрэг	873.7	2890.2		-2016.5
9	Тээвэр шатахуун	150.0	162.6		-12.6
10	Шуудан холбоо	1106.5	4327.2		-3220.7
11	Албан томилолт	342.6	312.6	30.0	
12	Төлбөр хураамж	200.0	200.0	0.0	
13	Ном хэвлэл	734.2	40.0	694.2	
14	Хог хаягдал	428.3	558.9		-130.6
15	Зөөлөн эдлэл	2055.7	2093.1		-37.4
16	БҮТЭЗ	1370.4	3050.5		-1680.1

17	Хичээл сургалт	9952.3	8018.6	1933.7	
18	Бусад зардал	1713.0	792.6	920.4	
19	Урсгал засвар	5364.0	5791.8		-427.8
20	Аудит баталгаажуулалт	400.0	792.0		-392.0
21	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	21924.1	21904.4	19.7	
22	ХОНТСА	98501.6	94902.6	3599.0	
23	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж	27900.0	27869.2	30.8	
24	Төвлөрүүлэх шилжүүлэг				
25	Төсвийн санхүүжилтээс	1363576.2	1363576.3		
26	НДСангаас				
27	Үйл ажиллагааны орлого	1405.4	1405.4		
28	Нийт зардал	1364981.6	1364981.7		
	Нэмэлт санхүүжилт				

2018 онд төсвөөс авах татаас санхүүжилтийн орлогоор 1273154.3 мянган төгрөг, өөрийн орлогоос 681.6 мянган төгрөг, нийт 1273835.9 мянган төгрөг татан төлөвлөрүүлж төсвийг захиран зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн хөрөнгийг зардлын зүйл ангилалаар авч үзвэл /мянган төгрөг/

ДД	Үзүүлэлт	2018 он		Хэмнэлт	Хэтрэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин	850777.3	850777.3		
2	НДШ	102093.2	102093.2		
3	Гэрэл цахилгаан	6829.7	7460.8		-631.1
4	Түлш халаалт	183888.6	187007.5		-3118.9
5	Цэвэр бохир ус	26402.2	26402.3		-0.1
6	Үдийн цай	51873.8	51266.3	607.5	
	Эм	394.0	394.0		
8	Бичиг хэрэг	1941.9	7051.5		-5109.6
9	Тээвэр шатахуун	150.0	200.0		-50.0
10	Шуудан холбоо	1226.5	1342.5		-116.0
11	Албан томилолт	234.0	234.0		
12	Төлбөр хураамж	700.0	700.0		
13	Ном хэвлэл	788.1	1532.8		-744.7
14	Хог хаягдал	428.3	428.3		
15	Зөөлөнэдлэл	1730.3	1730.3		

16	БҮТЭЗ	7386.7	7602.7		-216.0
17	Хичээл сургалт	8623.5	2872.4	5751.1	
18	Урсгал засвар	3254.9	2815.6	439.3	
19	Биеийн тамир, тэмцээн				
20	Аудит баталгаажуулалт	400.0	400.0		
21	ХОНТСА	22919.3	19718.3	3201.0	
22	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж				
23	Бусад зардал	1713.1	1806.1		-93.0
24	Ажил олгогчоос бусад тэтгэмж				
25	Төсвийн санхүүжилтээс	1273155.5	1273154.3		
26	НДСангаас				
27	Үйл ажиллагааны орлого	600.0	681.6		
28	Нийт зардал	1273755.5	1273835.9		
	Нэмэлт санхүүжилт				

2019 онд төсвөөс авах татаас санхүүжилтийн орлогоор 1531403.2 мянган төгрөг, өөрийн орлогоос 1242.5 мянган төгрөг, нийт 1532645.7 мянган төгрөг татан төлөвлөрүүлж төсвийг захиран зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн хөрөнгийг зардлын зүйл ангилалаар авч үзвэл /мянган төгрөг/

ДД	Үзүүлэлт	2019 он		Хэмнэлт	Хэтрэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин	1,086,699.8	1092199.8		-5,500.00
2	НДШ	135,837.5	130980.0	4,857.50	
3	Гэрэл цахилгаан	5,718.2	5,718.2	0.00	
4	Түлшхалаалт	203,676.3	203708.6		-32.30
5	Цэвэр бохир ус	26,397.1	26,397.1	0.00	
6	Үдийн цай	53,599.2	53,599.2	0.00	
7	Эм	385.9	385.9	0.00	
8	Бичиг хэрэг	877.1	863.7	13.40	
9	Тээвэр шатахуун	100.0	100.0	0.00	
10	Шуудан холбоо	1,299.9	1290.0	9.90	
11	Албан томилолт	330.0	330.0	0.00	
12	Төлбөрхураамж			0.00	
13	Ном хэвлэл	807.0	805.5	1.50	
14	Хог хаягдал	438.6	438.6	0.00	
15	Зөөлөнэдлэл	1,701.6	1,701.3	0.30	
16	БҮТЭЗ	1,368.3	1,368.3	0.00	
17	Хичээл сургалт	8,494.2	8,597.6		-103.40
18	Урсгал засвар	1,726.9	1,726.9	0.00	
19	Биеийн тамир, тэмцээн			0.00	
19	Аудит баталгаажуулалт	879.1	1008.0		-128.90

20	Бусад зардал	2309.0	1427.0	882.00	
21	ХОНТСА				
22	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж				
23	Ажил олгогчоос бусад тэтгэмж				
24	Төсвийнсанхүүжилтээс	1531403.2	1531403.2		
25	НДСангаас				
26	Үйл ажиллагааны орлого	1242.5	1242.5		
27	Нийт зардал	1532645.7	1532645.7		
	Нэмэлт санхүүжилт				

2019 оны эхэнд авлагын үлдэгдэл 1971.1 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 219.9 мянган төгрөг болж буурсан байна. Харин өглөг оны эхэнд 257.9 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст үлдэгдэлгүй болж нийт өр төлбөрөө барагдуулсан байна.

Зургаа. Өмнөх шалгалтын талаар

Жаргалант сумын 12 жилийн 6-р сургууль нь 2016, 2017 оны жилийн эцсийн тайлангийн аудитаар “Зөрчилтэй” 2018, 2019 онуудад “Зөрчилгүй” санал, дүгнэлт авсан байна.

Долоо. Шалгалтаар илэрсэн ололттой талууд

1. Сар бүр санхүүгийн тайлангийн мэдээ мэдээллийг багш ажилчдад танилцуулж хэвшсэн.
2. Нягтлан бодох бүртгэлийг программаар гаргаж хэвшил болсон.
3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн биелэлтийг сар бүр тогтмол гаргаж мэдээллийг бүрэн оруулсан.

Найм. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

1. Албан томилолтыг анхан шатны баримтын бүрдэл болоогүй байхад олгосон нь Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 12 дахь заалт аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/518 тоот захирамжийг тус тус зөрчиж байна.

2. Сургуулийн захирлын 2017.12.20-ны А/106 тоот тушаалаар төрийн албан хаагчдад нэг удаагийн урамшууллыг 2017 онд шинээр ажилд орсон, чөлөөтэй, бүтэн ажиллаагүй ажилчдад ажлын үр дүнг харгалзан тооцолгүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.7 дахь заалтууд, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 16.5.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6. дахь заалт, Улсын их хурлын 2017 оны 12 дугаар сарын 67 дугаар тогтоолын 1.1 дэх заалт,

Засгийн газрын 2017 оны 12 сарын хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.8, 80.2 дэхь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3. 2017 оны 12 сард Төрийн албан хаагчдад олгосон урамшууллыг 2017 оны 10,11,12 дугаар саруудад ажилж байсан химийн багшид ажилсан хугацаанд ногдохыг олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дахь заалтууд, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 16.5.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6. дахь заалт, Улсын их хурлын 2017 оны 12 дугаар сарын 67 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 12 сарын хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.8, 80.2 дэхь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4. 2018 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан сургуулийн захирлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний А/81 тоот, 2018.12.20-ний А/82 тоот тушаалуудаар хуулийн заалтыг дахин давтан гаргаж, илүү тооцсон, ажил дүгнээгүй А,В,С үнэлгээг авсан оноонд харгалзуулан тооцоогүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.7 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолын хавсралт, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 13-ний А/293 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам байгууллагын дотоод журам хамтын гэрээг зөрчиж байна.

5. 2016-2017 онуудад архив албан бичиг хэргийн хөтлөлт хангалтгүй, тушаал шийдвэр архивласан, дугаар зөрүүтэй байна.

6. 2018 онд санхүүгийн тайлангаар НДШ-н авлага 17,7 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 1953,4 мянган төгрөг, нийт 1971,1 мянган төгрөг, 2019 онд 219,9 мянган төгрөгийн цалингийн авлагыг тус тус тооцон баталгаажуулаагүй цалингийн зардлын хэмнэлтийг илүү шилжүүлсэн нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

7. 2019 онд аймгийн Татварын хэлтэсээс татварын хяналт шалгалтаар нийт 1068,7 мянган төгрөгийг акт тогтоосныг байгууллагын төсвөөс цалингийн зардлаас шууд барагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

8. 2019 оны 12 сарын 20-ний өдрийн төлбөрийн хүсэлтээр 6 дугаар сургуулийн нэмэлт данснаас ажилтны дансанд анхан шатны баримтгүй сургалтын зардал 1440,0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь

заалтууд, Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1-р хавсралтын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.3 дахь заалт зөрчсөн байна.

9. Тус сургуулийн өмнөх оны Бага үнэтэй түргэн элэгдэх хөрөнгийн чанартай бичиг хэрэг хангамжийн материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргаагүй сургуулийн захирлын тушаал шийдвэргүй ажилчдад танилцуулсан хурлын тэмдэглэл үйлдэлгүй нярав шаардах хуудсаар зарлагдсан нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтуудыг зөрчсөн байна. /4577600-1257100=3320500 төгрөг/

Ес. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тус хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа бөгөөд энэ хуультай холбоотой тус байгууллага нь батлагдсан төсөв болон санхүүгийн жилийн мэдээллийг самбараар мэдээлж байна. Шилэн дансны нэгдсэн системд 2016-2019 оны байдлаар мэдээллийг байршуулж хэвшсэн байна.

Арав. Авсан арга хэмжээ

Шалгалтаар нийт 9245616 төгрөгийн зөрчил илрүүлж 5038116 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар 1207500 төгрөгийг тухайн байгууллагад орлого авах улсын байцаагчийн актыг тус тус тогтоож 3320500 төгрөгийн зөрчлийг арилгахаар хугацаатай үүрэг болголоо.

Шалгалтын явцад MP09SFXP-MP09KK28, MP09SGLJ-MP09TUBB, MP09SFGA-MP09SFGA, MP09K3Z8-MP09UD3X серийн дугаартай зөөврийн компьютерууд ID код бүртгэлийн дугаартай зөрүүтэй дутагдсан тул тус тус ID кодтой зөөврийн компьютерээр сольж байгууллагын данс бүртгэлд тусгаж 6 дугаар сургуулийн хөрөнгөд орлого авахуулахаар акт тогтоов.

Арван нэг. Дүгнэлт

Тухайн байгууллагад хөтлөгдөж буй НББ болон өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэвийн хэмжээнд явагдаж, тайланг хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагуудад хянуулан баталгаажуулсан, шилэн дансны хууль хэрэгжсэн боловч Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.7, 6.4.8. дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 16.5. дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6. дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1-р хавсралтын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.3 дахь заалт зөрчсөн.

Арван хоёр. Цаашид авах арга хэмжээний санал

1. Төсвийг үрэлгэн зарцуулахгүй байх.
2. Улирлын үр дүн болон ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын шалгуур үзүүлэлт барьж дүгнэн олгож байх.
3. Лист амралт цалин давхардуулан олгохгүй байх.
4. Урьд оны дансны авлага, өглөгөө барагдуулах тайлангийн хугацаанд өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах.
5. Бага үнэтэй түргэн элэгдэх хөрөнгийг сургуулийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын тушаалаар данс бүртгэлээс хасах.
6. Шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар анхааран ажиллаж, шалгалтын мөрөөр хийсэн ажлын тайлангийн биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны дотор Ховд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр гарган ирүүлэх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА